

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БУС, ХҮНД СУРТАЛ, ЧИРЭГДЭЛТЭЙ БАЙДЛЫН ТАЛААР ИРГЭДИЙН ГОМДОЛ, САНАЛ ХҮЛЭЭН АВАХ 1977 УТАСНЫ 12-Р САРЫН ТАЙЛАН

АТГ төрийн байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээнд гарсан зөрчлийн талаархи гомдол, саналыг хүлээн авах 1977 /энгийн ярианы тарифтай/ утсыг нээлттэй ажиллуулан, ирсэн мэдээллийг судлан үзсэнээр тухайн байгууллагын удирдлагад үйл ажиллагаандаа гаргасан зөрчлөө нэн даруй арилгах арга хэмжээ аван, эргэж мэдээлэхийг үүрэг болгох шаардлага хүргүүлэн ажилласан болно.

“Глоб Интернэшнл” ТББ нь 1977 утсаар 2007 оны 07 дугаар сарын 09–нөөс эхэлж, энэ оны 12-р сарын 25-ныг дуустал иргэдээс төрийн байгууллагуудын хүнд суртал, төрийн үйлчилгээний ил тод байдал хангалттай бус байгаа талаар гомдол саналыг хүлээн авч, сар бүрийн 05-ын дотор нэгтгэн АТГ болон өөрийн вэб сайтаараа олон нийтэд мэдээлж байв.

2007 оны 12 дугаар сарын 01-нээс 25-ныг дуустлахи хугацаанд 1977 утсаар нийт 10 иргэн холбогдож, төрийн байгууллагын ажилтан, албан тушаалтны үйл ажиллагааны зөрчилтэй холбоотой гомдол гаргаснаас 8 иргэн Улаанбаатар хотоос, 2 иргэн Дархан уул, Говьсүмбэр аймгаас тус тус байна. Үүнд:

Иргэдийн гомдол гаргасан байгууллага, албан тушаалтнуудыг авч үзвэл ЭМЯ-ны эмч нарт лиценз олгох албаны лиценз хариуцсан ажилтан Болдбаатар нь эмч нарыг лиценз авахад өгдөг төстийн шалгалтанд зориуд унагааж, мөнгө нэхдэг. Бүр тогтсон жишигтэй болсон бөгөөд эмч нараас 100.000 – 150.000 төгрөг, сувилагчдаас 50.000 -100.000 төгрөг тус тус авдаг;

Нийслэлийн 11-р дунд сургуулийн захирал Үүрцайх нь 9 дүгээр сараас хойш санхүүжилт байхгүй гэсэн шалтгаанаар ажилчиддаа цалин тавьж өгөөгүй. Удирдах чадваргүй, ёс зүйгүй. Үе үе УМХА-наас хүн ирж шалгахаар архиуулаад явуулчихдаг;

СБД-ийн газрын албаны байцаагч Батаа нь 2001 онд Санзайн цаад талд манай газар дээр айлын хашаа буулгаж газар давхардуулж олгосон;

Нийслэлийн цагдаагийн газрын халаасны хулгайтай тэмцэх тасгийн дэд хурандаа Алтансүх, ахлах ахлагч Мөнхзориг нар нь ажил үүргээ хийдэггүй, хүнд суртал гаргаж иргэдийг чирэгдүүлдэг ба ёс зүйгүй харьцдаг;

Тээврийн прокурорын газрын прокурор Энхтуулаас, хохирогчтойгоо харилцан тохиролцсоны үндсэн дээр хохиролгүй болгоод, 12-р сард хураалгасан бичиг баримтаа авахаар очиход миний үзэгний үзүүрээр чиний асуудал шийдэгдэнэ гэж заналхийлж гэж ёс зүйгүй харьцаж хэрэгтэй танилцаагүй; Говьсүмбэр аймгийн шүүхийн шийдвэр биелүүлэх албаны ахлах шийдвэр гүйцэтгэгч Цэрэндорж шүүхийн шийдвэр гүйцэтгэж өгөхгүй ард иргэдийг ихээр чирэгдүүлж байна. АТГ-аас албан тоот очсон боловч асуудал шийдэгдээгүй. “Тэр АТГ чинь юу ч биш, та их олон газраар явж хөөцөлдсөн байна. Тэр чинь надад хамаагүй” гэж ёс зүйгүй харьцсан. Даргатай нь уулзах гэхээр утсаа авдаггүй;

Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газрын засаг дарга Амарсайхан нь 10 дугаар сард хүний эзэмшлийн газрыг давхардуулж өөр хүнд өгсөн байна. Газраа эргүүлж авъя гэхээр газрыг чинь эргүүлж олгохгүй гэж загнадаг;

Улаанбаатар хотын түргэн тусламжийн газрын дарга Ц.Пүрэвдаш нь ажилчдаа харааж доромжилж, хавчин гадуурхах зэргээр зүй бусаар харьцдаг. Мөн ерөнхий ня-бо-гийн гарын үсэггүйгээр дур мэдэн 7 сая төгрөгийн мебель зээлээр авч тавьсан. Хувийн бизнесээ улсын мөнгөөр хийдэг;

БГД-ийн татварын хэлтсийн даргын нарийн бичиг 12 дугаар сард зохих бүх бичиг баримтаа бүрдүүлсэн ба тодорхой хэмжээний мөнгө буцааж авах ёстой боловч одоо болтол авч чадахгүй байна. Даргын нарийн бичиг нь 2-3 хонгийн дотор олгодог гэсэн боловч одоо болтол олгоогүй;

Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн Маркетингийн тэнхмийн багш Бадамцэцэг оюутнуудын шалгалтын дүнг зориуд бага тавьж ном ав гэж шахдаг. Авахгүй бол дүн тавьж өгдөггүй. Ном шахаж байгаа бичлэг байгаа.